

Эхэд тулгуурлан багц даалгаврууд гүйцэтгэх тул доош гүйлгэн бүх даалгаврыг ажиллана уу!

“Шингэн алт үйлдвэрлэгч шидтэн”

Дэлхий дээр олон төрөл зүйлийн зөгий байх боловч түүний дотроос бүлээрээ зохион байгуулалттай амьдардаг балт зөгийг хүмүүс гаршуулж, арчилж өсгөн бүтээгдэхүүнийг нь авч ашигладаг. Иймээс та бүхэнд ажилч бяцхан зөгий хэрхэн яаж амьдарч, ажиллаж шингэн алт хэмээгдэх зөгийн бал болон бусад тансаг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, түүнийг нь ахуй амьдралд хэрхэн хэрэглэдэг талаар танилцуулъя.

Зөгий нь бүлээрээ амьдардаг шавж бөгөөд зөгийн бүлийн бүрэлдэхүүнд нэг эх зөгийн, хэдэн арван заримдаа хэдэн зуун эр зөгий, олон мянган ажлын зөгий, янз бүрийн насны авгалдайнууд багтдаг. Зөгийн бүлийг үндэслэгч нь эх зөгий юм. Тэрээр 1-5 жил амьдрах бөгөөд бусдаасаа том биетэй 20-25 мм урт, 150-300 мг жинтэй байдаг. Зөвхөн өндөглөх л үүрэгтэй. Эр зөгий том нийлмэл нүдтэй хатгуургүй, толгой бие, далавч томтой 17 мм орчим урт биетэй. 250-260 мг жинтэй. Эр зөгий эм зөгийг хээлтүүлээд үхдэг. Харин ажлын зөгийн биеийн урт нь 12-14 мм, 100 орчим мг жинтэй. Нас бие гүйцсэн ажлын зөгий нь хайгуулд явж балт ургамлын цэцэглэн байгаа газрыг эрж олох, амтат шүүс, цэцгийн тоос жилий цуглуулах, ус авчрах үүрэгтэй. Зөгийн гэр нь цэвэр, агааржуулалт сайтай, дулаан байх ёстой бөгөөд үүр болон жаазны зарим хэсгүүдийн зай, хэмжээ стандартын дагуу хийгдсэн байдаг.

Зөгийн балтай усыг уух явцад гарах хүний биед ашигтай үр дүнг дагалдах ашиг тус гэнэ. Зөгийн балтай ус нь амаар ороод бөөрөөр шээс болон гадагшлах хүртлээ шүдний шарлалтыг алга болгож, буйлны үрэвслийг анагаах, хэлний угт бактери үржих, амнаас эвгүй үнэр гарахыг болиулж, ходоодны шархлаа, нарийн гэдэсний халдвараас урьдчилан сэргийлүүлж, хорт хавдрын эрсдэлийг 70 хувь хүртэл бууруулдаг.

Эрдэмтэд олон жилийн судалгаагаар зөгийн балын дээрх ашиг тусыг баталсан байдаг. Хэрэв хүн ходоод гэдэсний тогтолцоогоо эрүүлжүүлж чадвал урт наслах боломжтой юм.

Монгол хэлний даалгаврууд

1. “... балт зөгийг хүмүүс гаршуулж” өгүүлбэрийн “гаршуулах” хэмээх үгийн утгыг зөв тайлбарласан нь аль вэ?
 - A. өсгөн торниулах
 - B. асарч тордох
 - C. анхаарч халамжлах
 - D. сургах зүгшрүүлэх
2. Цогцолбор бүрд юун тухай дүрсэлсэн байна вэ?

1) I цогцолбор	а. Зөгийн балтай ус уухын ашиг тусын талаар
2) II цогцолбор	б. Зөгийн балын ашиг тусыг ойлгох тухай
3) III цогцолбор	в. Зөгий, зөгийн балыг таниулах учир шалтгааны тухай
4) IV цогцолбор	г. Зөгийн ерөнхий мэдээллийн талаар

A. 1в, 2г, 3а, 4б B. 1б, 2г, 3а, 4в C. 1в, 2г, 3б, 4а D. 1б, 2а, 3г, 4в
3. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
 - A. Зөгийн балтай ус нь үрэвслийг анагаах, хэлний угт бактери үржих, ... нарийн гэдэсний халдвараас урьдчилан сэргийлэх, хорт хавдрын эрсдэлийг 70 хувь хүртэл бууруулдаг.
 - B. Иймээс та бүхэнд ажилч бяцхан зөгий хэрхэн яаж амьдарч, ажиллаж ... бусад тансаг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, түүнийг нь ахуй амьдралд хэрхэн хэрэглэдэг талаар танилцуулъя.
 - C. Эрдэмтэд олон жилийн судалгаагаар зөгийн балын дээрх ашиг тусыг баталсан байдаг.
 - D. Хэрэв хүн ходоод гэдэсний тогтолцоогоо эрүүлжүүлж чадвал урт наслах боломжтой юм.

4. Зохиогчийн санаа аль өгүүлбэрт илэрч байна вэ?
 - A. Эрдэмтэд олон жилийн судалгаагаар зөгийн балын дээрх ашиг тусыг баталсан байдаг.
 - B. Иймээс та бүхэнд ажилч бяцхан зөгий хэрхэн яаж амьдарч, ... түүнийг нь ахуй амьдралд хэрхэн хэрэглэдэг талаар танилцуулъя.
 - C. Хэрэв хүн ходоод гэдэсний тогтолцоогоо эрүүлжүүлж чадвал урт наслах боломжтой юм.
 - D. Зөгий нь бүлээрээ амьдардаг шавж бөгөөд зөгийн бүлийн бүрэлдэхүүнд ... олон мянган ажлын зөгий, янз бүрийн насны авгалдайнүүд багтдаг.
5. Яагаад зөгийн балтай ус уух хэрэгтэй вэ?
 - A. Шүдний шарлалт алга болж буйлны үрэвслийг анагаадаг учир
 - B. Хэлний угт бактери үржих, амнаас эвгүй үнэр гарахаа больдог учир
 - C. Дагалдах ашиг тустай учир
 - D. Хорт хавдрын эрсдэлийг бууруулах учир
6. Доорх загварт тохирох зөв хариулт аль нь вэ?
 Үр дагавар---- Шалтгаан-----Шалтгаан
 - A. Бактери үржихээ болих---зөгийн балтай ус уух---хавдрын эрсдэлийг бууруулах
 - B. Хавдрын эрсдэлийг бууруулах---бактери үржихээ болих---зөгийн балтай ус уух
 - C. Зөгийн балтай ус уух---хавдрын эрсдэлийг бууруулах---бактери үржихээ болих
 - D. Хавдрын эрсдэлийг бууруулах---зөгийн балтай ус уух--- бактери үржихээ болих
7. Эх зөгийнд холбогдох баримт аль вэ?
 - A. Хайгуулд явах
 - B. Эм зөгийг хээлтүүлэх
 - C. Ус авчрах
 - D. Зөгийн бүлийг үндэслэх
8. “Хэрэв хүн ходоод гэдэсний тогтолцоогоо эрүүлжүүлж чадвал урт наслах боломжтой юм.” нийлмэл өгүүлбэр хэрхэн холбогдсон байна вэ?
 - A. Цагийн утга зааж, “-вал” нөхцөлөөр холбогдсон.
 - B. Зорилгын утга зааж, “-вал” нөхцөлөөр холбогдсон.
 - C. Шалтгааны утга зааж, “-вал” нөхцөлөөр холбогдсон.
 - D. Орны утга зааж, “-вал” нөхцөлөөр холбогдсон.
9. Зөгийн балыг “шингэн алт” гэж нэрлэснийг хэрхэн дүгнэж болох вэ?
 - A. Алт шиг олон ашиг тустай учир ийн нэрлэсэн.
 - B. Алт шиг үнэт эрдэнэ учир ийн нэрлэсэн.
 - C. Алт шиг шар өнгөтэй учир ийн нэрлэсэн.
 - D. Алт шиг шар ч, шингэн тул ийн нэрлэсэн.
10. “Зөгийн гэр нь цэвэр, агааржуулалт сайтай, дулаан байх ёстой бөгөөд үүр болон жаазны зарим хэсгүүдийн зай, хэмжээ стандартын дагуу хийгдсэн байдаг.” өгүүлбэр дэх “бөгөөд” холбоосыг шалтгааны утгат холбох үгээр солин найруулахад аль нь тохирох вэ?
 - A. агаад
 - B. хийгээд
 - C. тэгэхлээр
 - D. учир

Уран зохиолын даалгаврууд

11. “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний сэцэлсэн шастир” зохиолд:

“Хурсан бүгд ууваас жаргал биш үү

Хол ойр сонсохул хүсэл биш үү” гэж хэн хэлсэн бэ?

- A. Бэсүдийн Зэв
- B. Ойрадын Хар Хиру
- C. Сүлдэсүний Сорхон шар
- D. Арулудын Хөлөг Боорчи

12. С.Дуламын “Хүмүүн бичиг” шүлэгт:

“Тимэм шүд нуруу шилбэтэй

Тэр чигээрээ хүн бичиг минь” гэсэн нь ямар дүрслэх хэрэглүүрээр бүтсэн бэ?

- A. Төлөөлөл
- B. Юмшуулал
- C. Адилтгал
- D. Егөөдөл

13. 3. Ж.Барамсайн “Цүнхтэй инээд” өгүүллэгт би баатар анхны зургаа хэнд үзүүлдэг вэ?

- A. Ахдаа
- B. Багшдаа
- C. Баяраад
- D. Алимаад

14. Хомерийн “Одиссей” зохиолд Хермес Эврилохт Эй арал дээрээс нөхдөө аврахад нь тусалж юу өгдөг вэ?

- A. Шидэт ундаа
- B. Шидэт ус
- C. Муна
- D. Моли цэцэг

15. “Эрийн сайн Хан Харангуй” туульд түүний ид хавыг хэрхэн дүрсэлдэг вэ?

- A. Эрхийтэнд авталгүй
Эгэмтэнд дийлдэлгүй
- B. Наян жилийн найр хийж
Амар сайхан жаргажээ
- C. Хангай дүүрэн хорин түмэн
Хонгор бараан адуутай
- D. Хөх уул түшигтэй
Мянга таван зуун настай

Үндэсний бичгийн даалгаврууд

16. “ёроол” үгийг зөв бичсэнийг олоорой.

A

ᠶᠣᠷᠣᠯ

B

ᠶᠣᠷᠣᠯ

C

ᠶᠣᠷᠣᠯ

D

ᠶᠣᠷᠣᠯ

17. Монгол бичгийг кирилл бичигт зөв буулгасныг олоорой.

۱. ۱۰۰٪
 ۲. ۹۰٪
 ۳. ۸۰٪
 ۴. ۷۰٪
 ۵. ۶۰٪
 ۶. ۵۰٪
 ۷. ۴۰٪
 ۸. ۳۰٪
 ۹. ۲۰٪
 ۱۰. ۱۰٪
 ۱۱. ۰٪

- A. Өндөр их заяатныг үзэн ядваас
Өөрийн амны хишиг зайлах
Өнчин хүний жаргалыг хөнөөвөөс
Өөрийн хишиг эвдрэх
- B. Өнөөдөр их заяатныг үзэн ядваас
Өөрийн амны хишиг зайлах
Өнчин хүний жаргалыг хөнөөвөөс
Өөрийн хишиг эвдрэх
- C. Өнөөдөр их заяатайг үзэн ядваас
Өөрийн амны хишиг зайлах
Өнчин хүний жаргалыг хөнөөвөөс
Өөрийн хишиг эвдрэх
- D. Өнөөдөр их заяатайг үзэн ядваас
Өөрийн амны хишиг зайлах
Өнчин хүний жаргалыг хөнөөвөөс
Өөрийн хишиг эвдрэх

18. Зөв хөрвүүлснийг сонгоорой.

[illegible]

- A.** Балар ойн хар замаар хийсэж яваа
Багваахай цэцгийн үр шиг гэрэлтээд ирэх нь юуных вэ?
- B.** Балар ойн хар жамаар хийсэж яваа
Багваахай цэцгийн үр шиг хэрэлдээд ирэх нь юуных вэ?
- C.** Балар ойн хар жимээр хийсэж яваа
Багваахай цэцгийн үр шиг гэрэлтээд ирэх нь юуных вэ?
- D.** Балар ойд хар замаар хийсэж яваа
Багваахай цэцгийн үр шиг хэрэлдээд ирэх нь юуных вэ?

19. Байдлын дагаврыг зөв залгасан бүлэг үгийг олоорой.

A
B
 ٢٠٢٠

72100

D


20. Бүтээврийг зөв залгасан бүлэг үгийг олоорой.

A

B

C

D